



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/280

Алтай хот

┌ Хөрөнгө гаргах тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажип, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дэхь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, мөн 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн "Аймгийн 2023 оны төсвийг тодотгон батлах тухай" 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын Жанчивын гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажилд 2023 онд санхүүжүүлэхээр батлагдсан 700,000,000 (долоон зуун сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас гаргаж, Есөнбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 100050152400 тоот дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Төсөл, арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР